

Г.Эрдэнэбаяр

Философийн тэнхимийн  
багш, доктор (PhD)

СОЁЛ БА ИРГЭНШЛИЙН ХАРИЛЦАН  
НӨЛӨӨЛЛИЙН АСУУДАЛ

Түлхүүр үг:

- ❖ Түүх
- ❖ Шашин
- ❖ Нийгэм
- ❖ Хөгжил

**Товч утга:** Энэ өгүүлэлд соёл ба иргэншлийн онолын хүрээнд соёлын харилцан нөлөөллийн асуудал хэрхэн тавигдсаныг тус онолын төлөөлөгч болох О.Шпенглер, А.Тойнби нарын үзлээр төлөөлүүлэн авч үзэх зорилго тавилаа. Соёл ба иргэншлийн онолоор бие даасан соёлууд нь бие биеэс үл хамааран оршдог гэж үзсээр ирсэн. Гэвч шууд утгаар ингэж ойлгох явдал нь арга зүйн хувьд алдаатай хэмээн үзэж байна.

Нийгэм, түүхийг авч үздэг соёл иргэншлийн онолоор бол бие биеэс тусгаар орших соёл иргэншлүүдийн хөгжил нь бие биедээ хараат бус, өөрөөр хэлбэл соёл ба иргэншлүүд бие биетэйгээ холбоогүй гэж үзэх хандлага давамгайлж байна. Тухайн соёлын дотоод зүй тогтол нь тэрхүү соёл иргэншлийн төлөв байдал хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж байдаг.

Орчин үеийг соёлын үе биш, харин иргэншлийн үе хэмээн О.Шпенглер тунхаглажээ. Шпенглерын хувьд иргэншил бол аливаа соёлын мөхлийн шатанд үүсэн буй болдог хэлбэршил юм. Тэрээр байгалийн хууль л зөвхөн бодитой байдаг гэсэн нь хүн төрөлхтний түүхэнд объектив зүй тогтол ноёрхдог тухай Гегелийн үзлийг баримтлаагүйнх нь нэг нотолгоо болдог.

Харин Гегелийн үзэлтэй ойртоож очих түүний нэг үзэл санаа нь: оюун ухаан бол хэрэгжих ёстай зүйл мөн. “Ертөнц” бол хэрэгжсэн зүйл, харин амьдрал бол жинхэнэ хэрэгжиж буй зүйл юм. Ирээдүйн хувь заяаг оюун санаа тодорхойлдог гэдэг үндэслэл юм. Шпенглерийнхээр оюун ухаан бол зөвхөн бодьгал тус тус бүрдэл мөн бөгөөд ийм шинж эцэс төгсгөлгүй илэрдэг бусад оюун ухаанд хамаардаг. Иймд тэдгээр нь тус бүрдээ өөртөө тохирсон ертөнцийг зохиодог. Тэгвэл ертөнцийн тухай нэгдмэл нэг, объектив агуулгатай мэдлэг байх үндэсгүй юм. Тэрээр ийм санааг шууд илэрхийлж: “Хичнээн хүн, соёл байна, төчнөөн ертөнц байдаг бөгөөд аливаа тусгай хүний оршин байхуйд ганцаараа, бие даан, мөнх мэт байдаг энэ ертөнц бол байнгын шинэ, нэг л удаа оршдог, хэзээ ч үл давтагдах зовнин мэдрэхүй мөн. Энэ тухай хүн бүр бodoхдоо ийм ертөнц бусад хүнд ч яг тийм байдаг гэж үздэг” хэмээн бичжээ.

Асуудал хэдийгээр ийнхүү тавигдаж байгаа ч түүний үзэл санааг бүхэлд нь судлан үзвээс аливаа улс үндэстнүүд (соёлууд) бие биендээ харилцан нөлөөлөх тухай санаа зарим нэг зүйл дээр гарч ирж байна.

Тэрээр “Европын гудайлт” зохиолынхоо хоёрдугаар ботид “хоёр соёл хоорондоо харилцан нөлөөлнө гэдэг нь хоёр соёлын хүн өөр хоорондоо харилцах, эсвэл нэг соёлын хүн нөгөө соёлын мөхсөн хэлбэрийг харж байхад харилцах юм” гэжээ. Энд Шпенглерийн хувьд соёл гэдэг бол угтаа нийгэм гэсэн ойлголттой ижил утгаар ойлгогдож байна. Үүнийг нотлох зүйлийг дээрх зохиолоос дурдья. Үүнд, соёлуудын харилцаа холбоо нь олон янз байдлаар илэрдэг. Энэ нь орон зай хийгээд цаг хугацааны хоцролоос үндэстэй юм. Загалмайтны аян дайны эсрэг эртний соёл иргэншил (аль ч талаараа боловсорсон) сөрөн зогсож байлаа. Соёл иргэншил нь өөрийн гэрэл гэгээгээ эцэс төгсгөлгүй алс холбоос ч илгээх боломжтой байдаг. Жишээлбэл, арабын ертөнцөд үзүүлсэн Энэтхэгийн соёлын нөлөөг энд хэлж болох юм.

Янз бүрийн соёлын харилцан биендээ үзүүлэх нөлөө нь тэдгээр соёлын хүч, хөгжлийн түвшингээс хамаардаг. Тухайлбал, барууны соёл бусадтай холбогдох холбоо эрж хайж байхад, Египетийн соёл түүнээс зайлсхийж байх жишээтэй байна. Энэхүү харилцан нөлөөлөл нь эцсийн дүндээ тухайн соёлын оюун санаагаар нөхцөлдөж байдаг.

Соёлуудын харилцан нөлөөлөл нь тухайн соёлт ард түмний хэл яриагаар дамжиж хэрэгждэг гэсэн санааг Шпенглер олонтаа дурьджээ. Хэл ярианы хүчээр хүмүүс өөр хоорондоо харилцахын зэрэгцээ хэдэн зууны өмнөх хийгээд олон мянган километрээр алслагдсан хүмүүс бие биээ ойлгоход чухал ач холбогдолтой байна.

Нөгөө талаас соёл бүхэн өөрийн санаатай байна. Тэрээр эртний; баруун-европын; арабын гэсэн гурван түүхэн соёлыг авч үзжээ. Эдгээрт гурван санаа хамаарч байдаг.

- 1.Аполлонын буюу эртний соёл
- 2.Фаустовын буюу баруун европын соёл
- 3.Маги буюу арабын соёл

Энэ гурван хэлбэр бие биеэсээ ялгарах, тэднийг тодорхойлж байдаг гол зүйл бол урлаг мөн. Энд уран барилга, яруу найраг, хөгжим зэрэг урлагын төрөл орж байдаг. Энэ үүднээсээ жишээлбэл эртний соёл хийгээд барууны соёл хоёр эсрэг тэсрэг шинжтэй гэж дүгнэсэн нь буй.

Энд нийгмийг урлагийн төрлүүдээр дамжуулан ойлгох Шпенглерийн арга зүй нь гарч ирж байна. Танин мэдэхүйг урлагийн төрлүүдээр илэрхийлэн тайлбарлах байдал урьд нь Германы сэтгэгч В.Дильтейд (1833-1911) илэрч байсан. Дильтей мөн хүн төрөлхтний түүх бол бие биенээсээ үл хамаарах түжигдмэл соёлын

системүүдээс тогтдог гэдэг үзлийг ч мөн дэвшүүлж байжээ. Түүнийг нь Шпенглер уламжлан хүлээн авчээ.

Ийнхүү нийгмийг танин мэдэхүйг зөвхөн урлаг судлалаар орлуулан тайлбарлах нь нийгэм, түүхийн үзлийг тайлбарлах үндэс нь болдог. Тухайлбал, Шпенглер эртний түүх, урлагийн бүтээлүүдийг авч үзээд тэдгээрт гарч буй үйл явдалтай төсөөтэй өнөөгийн үйл явдлуудыг олж тогтоохыг чармайж байсныг түүний зохиол бүтээлээс олж харж болно. Улмаар эндээсээ өrnөдийн соёлыг аврах улс төрийн тохиромжтой загвар олох эрэл хийжээ. Тухайлбал, эртний Грек дэх Македоны Александрын байлдан дагуулалт, Наполеоны байлдан дагуулалт хоёр нэг үеийн ижил үзэгдэл мөн гэж үзсэн нь буй. Аливаа соёлын хувь заяа ирээдүй рүү биш угтаа өнгөрсөн рүү чиглэсэн байх ёстой. Харин тухайн соёлын хөгжлийн үе шатны солигдоор (үүсэл, өrnөл, бууралт) тухайн соёлын өнгөрсөн хийгээд ирээдүйн хөгжлийн шатыг тодорхойлж болно гэсэн санааг тэрээр дэвшүүлжээ. Мөн соёл мөхөхөөрөө иргэншил болно. Грек, ромын соёл нь Эллинизмын үед (М.Э.Ө.III-I зуун), баруун Европын соёл нь өнгөрсөн зуунд ийм байдалд хүрчээ. Иргэншлийн үед нийтийг хамарсан соёл давамгайлж урлаг, уран сайхны үйл ажиллагаа бүтээлч шинжээ алдах ухаалаг бус технизм, спортод байр сууриа тавьж өгдөг. Баруун европын нийгэм нь Дорноос өrnөсөн “бүдүүлгүүдийн” хувьсгалд автан Ромын эзэнт гүрний хувь тавиланг давтана хэмээн Шпенглер үзжээ.

Шпенглерийн үзлийг цааш нарийвчлах зорилт тавьсан хүн бол Английн түүхч, социолог Арнольд Жозеф Тойнби (1889-1975) юм. “Түүх судлал” хэмээх 12 боть зохиолоороо ихэд алдаршсан түүнийг эдүгээ үед соёл иргэншлийн онолын томоохон төлөөлөгч хэмээн үзэж байна. Тэрээр энэхүү зохиолдоо хүн төрөлхтний иргэншлийн хувь заяа, хэтийн төлөвийн тухай асуудалд хариулах оролдлого хийсэн байна. Тойнби анхандаа Шпенглерийн үзлийг баримталж түүх бол үүсэл, хөгжил уналтын хувьд өөр хоорондоо холбоогүй зэрэгцэн хөгжих иргэншлүүдийн нийлбэр хэмээн үзэж байжээ. Харин Тойнби олон боть зохиолынхoo төгсгөл үед өөрийн онолоо хянан үзэж, түүхэнд тохиолдсон бүх иргэншил бол “түүхийн нэгэн модны” мөчрүүд юм гэсэн дүгнэлт хийжээ. Энэ нь хүн төрөлхтний урагшлах хөдөлгөөнд нэгдэх хандлага байж, иргэншил бүхэн энэ нэгдлийн хэсэг байдаг гэсэн утгатай юм. Ийм баримтлал ёсоор бол даян дэлхийн түүхэн хөгжил нь хүн төрөлхтөн тусгаар нэгдлээс (нутгийн иргэншлээс) эцсийн түгээмэл ерөнхий тийш буюу нийт хүн төрөлхтний нэгдмэл иргэншил тийш явах хөдөлгөөн юм.

Ийнхүү орчин үед соёл, иргэншил хоёрын холбоог авч үздэг түүхч, философич судлаачид Шпенглер соёл, иргэншил хоёрын харилцааны асуудлыг авч үзсэн арга зүйг нь өндөрөөр үнэлэхдээ харин онолын баримтлалд нь нэлээд шүүмжлэлтэй ханддаг юм.

Иргэншлийг Тойнби ангилахдаа дотоод холбоо, газар зүйн орчин, арьсны өнгө, шашин зэрэг олон шалгуураар авч үзэж

анхандаа 19-21 иргэншлийг авч илрүүлэн, эцэст нь 13 иргэншил дээр тогтжээ Иргэншил бол буддизм, христос, лал гэх мэт дэлхийн томоохон шашнаас тэтгэлгэ авч байдаг хэмээн үзжээ. Мөн түүхийн хөгжилд бурхан тэнгэрийн хувь нэмрээс гадна суут хүмүүс, “бүтээлч цөөнх” идэвхтэй хөдөлгөгч хүчин болдог гэж тэрээр үзэж байв.

Энэ цөөнх нь идэвхгүй олонхийг дагуулж түүний шилдэг хэсгээр сэлбэгдэн, бусад соёл болон гаднын дуудлагад “хариулт” өгсөөр тухайн нийгэм урагшлана. Яваандаа энэ цөөнх нэр хүндээр бус, зэвсгийн хүчээр засаглалаа тогтоогч “ноёлогч элит” болж хувиравал тэднээс ангижирсан олон түмэн “дотоод пролетари” болж гаднах хүчинтэй хавсарч уг иргэншлийг хөнөөх аюултай юм гэж тэрээр бичсэн байдаг.

Түүнчлэн Тойнби хүн төрөлхтний хөгжлийн урагшлах хөдөлгөөн нь шашин мөн бөгөөд ирээдүйд хүн төрөлхтөн нэгдмэл нэг шашинтай болно гэж үзэж байжээ.

Цааш нь, Тойнби газар зүйн байршилаар нь иргэншлийг хуучин иргэншил, шинэ иргэншил гэж ангилжээ.

Азийн улс гүрнүүд тухайлбал, хятад, энэтхэг, арабын цэрэг дайныхан ба худалдаачид баруун европын улсуудтай эдгээр холбоо харилцаатай байжээ. Энэ явдал нь тэдгээр улс гүрнүүдийн хөгжилд чухал ач тус өгчээ. Африк тив гэхэд л олон соёлуудын уулзалдах талбар болж иржээ. Барууны иргэншил сүүлийн 500 жилд газар дэлхийн бусад бус нутгаас соёл хийгээд улс төрийн хувьд маш их зүйлийг өөртөө шингээсэн тухай дурьдсан нь буй. XY зууны үеийн далай тэнгисийн их нээлтүүд нь барууны иргэншил болон (Тойнби барууны иргэншлийг Шинэ гэрэл гэгээ гэж нэрлэжээ.) иргэншсэн хийгээд иргэншээгүй нийгмүүдийн хооронд холбоо тогтоож иржээ.

Мөн орчин үе бол барууны иргэншлийн эрин гэсэн санааг Тойнби олонтаа дурьдсан байдаг. Энэ нь эдүгээ Европ төвт иргэншлийн үе гэсэн санаа гэж ойлгож болох үндэстэй юм. Мөн түүний үзэлд хүчирхэг том гүрнүүдийн бусдад үзүүлэх нелөө их юм гэдэг санаа бий.\*\* Энд, жишээлбэл, Япон, Орос зэрэг улс гүрнийг дурьдажээ.

Өөр нэг чухал үзэл санаа гэвэл хүчирхэг соёл ба иргэншил хөгжлийнхөө уруудалтын шатанд орохдоо бусад соёлын нелөөг хүчтэй хүлээн авч, нэгэн зэрэг бусдад үзүүлэх нелөө нь мөн буурч ирдэг гэсэн санаа Тойнбид бий.

Тойнби соёл болон иргэншлийн хөгжилд шашны нелөөлөл хүчтэй байдгийг авч үзжээ. Дэлхийн шашин бусад соёлд нелөөлснөөс тухайн соёл хийгээд иргэншлийн хөгжилтөнд зэрэг, сөрөг нелөө үзүүлдгийг цохон тэмдэглэсэн байна. Хүн төрөлхтний иргэншлийн хөгжил нь цааш нэгдмэл болох чиг хандлагатай тухай асуудал нь Гегелийн үзэл санаатай ижил утгатай байна хэмээн үзэж болно.

Ийнхүү Шпенглер, Тойнби нар соёл иргэншлийн хөгжлийн үе шат, нас сүүдрийг баримжаалан гаргаж хүн төрөлхтний соёл

иргэншлийн дээд шатыг Өрнөдийн нийгмийн өнөөгийн хөгжлөөр төлөөлүүлэн тайлбарлажээ. Энд соёл иргэншлийн хөгжил Ази, Дорно дахинаас Өрнөд тийш шилжсэн гэдэг санааг тэд дэвшүүлсэн байна.

Соёл иргэншлийн хөгжлийн дээд шатыг Өрнө дахинь соёлтой холбож үзэхдээ соёл ба иргэншил нь өөр орчин нөхцөлд, тухайлбал, Дорно дахинд шинэ байдлаар цэцэглэн хөгжиж болох тухай үзэл санаа ч тэдэнд бий. Үүнтэй холбогдуулж Н.А.Бердяевийн бичсэн нэгэн зүйлийг иш татья. Н.А.Бердяев бичихдээ: “Түүхийн хувьд баруун Европын мандалт, бууралт гэдэг нь хуучин Европын соёл жаргаж байгаа, бүтээлч хүч нь сульдаж байгаа, урлаг, гүн ухаан, шашин нь төгсгөлдөө хүрч байгаа гэсэн үг юм. Соёл иргэншил үүгээр ч бас дуусахгүй соёл иргэншил ялалтынхаа оргилд хүрэх болно. Соёл нь өөр арьсны, өөр оюун ухааны хүрээнд цаашид цэцэглэх болно” гээд цааш нь “Эллинист хэмээх манай эриний онцлог шинж гэвэл Дорно, Өрнийн харилцан нөлөөллийн нэгдэл, бүх соёл, бүх арьстнуудын уулзалт, ойртолт, соёл иргэншлийн синкетизм, универсализм, түүний эрин үеийн төгсгөл, жаргалт ойртоож буй нь улам улам мэдрэгдэх болсон хэрэг юм. Манай энэ үед соёл иргэншил Өрнөөс Дорно руу хандах болж, нэн соёлт хүмүүс энэ соёлын гэрэл гэгээг Дорно зүйтэй эрэн хайх боллоо” гэжээ.

Эндээс бид иргэншлийн харилцан нөлөөллийн асуудлыг олж харж байна.

Ер нь аль нэг улс үндэстний эрхлэх аж ахуй, түүнийг дагалдах амьдралын хэвшил, улмаар нэг нь нэгээтийгээ хэрхэн харилцаа холбоотой байх нь айл зэргэлдээ орших улс үндэстний хөгжлийн уруудалт өсөлтийн хэр хэмжээ, улс төрийн бодлогын чиг шугам зэрэг өдий төдий хүчин зүйл, нөхцөл байдлаас шалтгаалдаг.

Аливаа үндэс угсаатан хөгжлийнхөө өгсөх шатанд ороход бусдын нөлөөнөөс гарч үндэстний уламжлалт соёлоо сэргээж улмаар хүч чадлыг олдог байна. Уруудалтын шатанд ороход хүч чадал нь доройтоож бусдын эрхшээлд орж өөрийн гэсэн бүхэн нь шинэчлэгдэн өөрчлөгднө.

Монголын ард түмний түүхийг төв Азийн орнуудын ард түмний түүхээс тусгайд нь авч судлах нь бэрхшээлтэй. Учир нь Монгол орны түүх соёл нь Азийн энэ газар нутгийн түүх соёлтой нягт холбогдсон байжээ. Эртний Энэтхэг, Иран, Уйгур зэрэг төв азийн бусад орны олон ард түмний соёлын эрдэнэс баялаг монголын ард түмний эрхэм хүртээл болж Монгол оронд өвөрмөц соёл бүрэлдэн хөгжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Монгол нь Ази тивийн төвд өргөн уудам газар дэвсгэрт байршиж, төв Азийн соёл иргэншлийн түүхэнд эрт цагаас нэлээд чухал байр эзэлж, Ази тивийн соёл иргэншлийн нэг голомт нь болж байжээ.

XIII зууны эхээр байгуулагдсан Монголын нэгдсэн улсын үед монголын соёлын түүхэнд мэдэгдэхүйц ахиц гарсан. Тэрхүү үйл явц урьд өмнө Монголд хөгжик ирсэн соёлын уламжлал ололтын үндсэн

дээр нийт монгол туургатны соёл бүрэлдэн тогтоход хүчтэй нөлөө үзүүлжээ.

### **Дүгнэлт**

Хүн төрөлхтний хөгжлийн түүхэн тодорхой үе бүрдэх бодит байдлыг шинжлэх зохистой онол, арга зүйг тогтоох бүтээлч эрэл хайгуул эдүгээ эрчимтэй өрнөж байна. Соёлуудын харилцан нөлөөллийн талаархи янз бүрийн үзэл онолыг судалгааны арга зүй болгон ашиглах явдал ихээхэн ач холбогдолтой болж байна.

### **Ном зүй:**

1. О.Шпенглер. Закат Европы М.,1993
2. А.Тойнби. Постижение Истории М.,1991